

Нийлэг хальсан хүлэмжинд шинэсний тарьц ургуулах технологи




Үрийг тариалалтад бэлтгэх

- Хураалт, хадгалалтын горим нь зөрчигдсөн үрийн ургах эрчим, соёололт мууддаг тул тарихын өмнө үрийг термостат, хатаах шүүгээ, зуух ашиглах буюу наранд дэлгэж ээх замаар зориуд халааж чанарыг нь дээшлүүлдэг. . Наранд халаахдаа үрийг 8-10 см зузаантай дэлгэж 50° - 60° халуунд 3 цаг халаана.
- Дараа нь үрийг тасалгааны температуртай усанд 48 цаг дэвтээнэ. Тэгэхдээ усыг 8-12 цаг тутам сольж байх хэрэгтэй.
- Үрийг 0,5% маргенц хүчлийн калийн уусмалд 2 цаг байлгаж ариутгана. Уусмал бэлтгэхдээ 1л усанд 5г маргенц оногдохоор тооцоолно.
- Ариутгасан үрийг цэвэр усаар зайлж нарны шууд тусгал тусахгүй хуурай сэрүүн газар нимгэн дэлгэж эврээгээд шууд тарина.




Үрийг цаслах

- Дэвтээж ариутгасан үрийг 4-5 кг-аар марлен уутанд хийж тэнийлгэхэд 2-3 см зузаан байхаар сүүдэртэй тэгш газар цасаар дарж дээрээс нь 40-60 см зузаан үртэсээр хучна.
- Цасласан үрийг нарны шууд тусгал тусахгүй хуурай сэрүүн газар нимгэн дэлгэж эврээгээд шууд тарина.



Хүлэмжийг тариалалтад бэлтгэх

- 1м өргөнтэй 4 туузыг дараах харьцаагаар байгуулна /20-100-50-100-60-100-50-100-20/
- Хашлага банз 4м урттай, 5 см зузаан 20 см өргөн банз 40 орно
- Хөрс бэлтгэхэд 20 м³ шороо шаардагдана. 60% нь хар шороо, 40% нь элс
- 18 м урттай 4 тууз 72м урттай болно /Хоёр талд нь 1,1 м зай гаргана/
- Тарьцыг мөөгөн өвчнөөс хамгаалахын тулд хөрсийг урьдчилан ариутгана.
- Ариутгахын өмнө хөрсийг урьдчилан нэвчтэл сайн усална.
- Дараа нь формалины уусмалаар хөрс, зам, модон хашлага, хүлэмжний хаяаг шүршинэ.
- Уусмал бэлтгэхдээ 10 л формалиныг 600 л усаар шингэлнэ.
- Шүршилт хийсний дараа хүлэмжийг битүү хааж 24 цагийг турш байлгаад хөрсийг сийрүүлж агааржуулна.



Мизризтой хөрс бэлтгэх

- Микоризтой хөрсийг хар модон ойн гүнээс модны үндэс орчмоос авна.
- 480п/м-т 100 кг микоризтой хөрс орно.
- Микоризтой хөрсийг нар салхинд гаргах хатааж хуурайшуулахгүй чийгийг нь алдуулахгүйгээр тарилтанд хэрэглэнэ.



Үр тарих

- Усалж ариутгаж бэлтгэсэн эгнээнд үр тарих хөндлөн ховилыг хооронд нь 15 см зайтай татаж гаргана. Нэг туузанд 120 эгнээ гарах бөгөөд энэ нь 120 пог.м болно. 4 эгнээ нь нийт 480 пог м болно.
- Хэрэв үр тарих эгнээг 10 см зайтай гаргавал . Нэг туузанд 180 эгнээ гарах бөгөөд энэ нь 180 пог.м болно. 4 эгнээ нь нийт 720 пог м болно.
- 1 пог м-т 7 гр үр орох нормтой бөгөөд үрийн соёололт 63% буюу харьцангуй бага байгаа тул нормыг ихэсгэж 10 гр-аар тооцно. Ингэхэд 480 пог/м-т 4,8 кг, 720 пог/м-т 7,2 кг үр шаардагдана.
- Үр тарих ховилыг 3 см гүнтэйгээр жигд татаж гаргана.
- Гаргасан ховилын 1,5 см-т микоризтой шороо хийх өгнө. Хийж буй микоризтой хөрс хуурайшиж хатаагүй унаган чийгтэйгээ байх ёстой.
- Микоризтой хөрс хийсэн нэг ховилд 10 г үр ногдохоор үрийг жигд хийнэ.
- Үр хийсний дараа тээрээс нь 1,5 см зузаан хар шороо шим бордоо тэнцүү хольж бэлтгэсэн хөрсөөр хучиж тэгшилнэ.
- Үр тарьсны дараа үрийг хөрстэй авцалдуулахын тулд



Усалгаа

- Үр тарьснаас хойш цухуйж гартал өдөрт 2 удаа өглөө 6-9 цаг, орой 17-20цагт, 1м² талбайд 2-3 л ус орохоор услана.
- Усалгааг мананцар үүсгэгчээр болон гар шүршүүрээр гүйцэтгэнэ.
- Цухуйцын жинхэнэ шилмүүс үүсч, тарьц ургаж эхлэх хугацаанд 1 м талбайд 5-10 л оногдохоор услана. 7 сарын сүүл хүртэл
- Хүйтэн бүрхэг, бороо хуртай бол 1-2 өдөр өнжиж болно.
- 8 сард 7-11 хоногт 1 удаа 1м талбайд 10 л оногдохоор гүйцэтгэнэ.
- Хөрс хөлдөхөөс 7 хоногийн урьд буюу дулаалга хучилт хийхийн өмнөхөн 3-5 өдрийн турш 1 м талбайд 40-50 л оногдохоор цэнэг усалгаа хийнэ. Тэгэхдээ 1 удаагийн усалгаанд 10 л-ээс хэтрүүлэхгүй түрүүчийн ус сайн шингэсний дараа хийх зэргээр 5-6 удаа тасалж хийнэ.



Хүлэмжний бичил уур амьсгал ба түүнийг зохицуулах

- Шинэсний тарьц ургуулахад 5-10 см-ын өндөр дэх агаарын температур 30- 35° хөрсний гадаргын температур 40°-аас илүүгүй , агаарын харьцангуй чийгшил 70-80%, хөрсний чийг 60-70%, хөрсний температур 20-25° байвал зохино. (термометр, психометр,)
 - Агаарын температур 30°-аас дээш гарвал сүүдрэвч тороор бүтээх
 - Шаардлагатай бол хөрс, ургамлын халалтыг бууруулах зорилгоор түр зуурын усалгааг хийнэ.
 - 6-8 сард нарлаг, салхигүй өдөр үдийн 12-17 цагийн хүртэл хүлэмжийн салхивчийг онгорхой байлгах нь зүйтэй.



Хөрсийг сийрүүлэх ба хог ургамлыг устгах

- Хүлэмж, бүрхэвчин дэх хөрсийг эхний удаа цухуйж гарснаас хойш 20-25 хоноод сийрүүлнэ. (дараа нь 2 долоо хоногт 1 удаа)
- Эхний удаа 2-3 см, дараа нь 3-5 см хүртэл гүнд сийрүүлнэ.
- Хог ургамлыг гарч ирсэн тухай бүрт нь устгах 13

Нэмэлт бордоогоор бордох

- Үр цухуйц жигдэрснээс хойш 2 долоо хоноод азот, фосфор, калийн давсны уусмалаар 1м талбайд (N=15g, P=15g, K=2g) дараа нь N-ыг 6-10 г-аар бодож 2 долоо хоног тутамд 1 удаа нэмж бордоно.
- 7 сарын сүүлээр P, K давсны уусмалыг 1м талбайд тус бүр 2г ноогдохоор ургамлыг шүршинэ.
- 1м талбайд 10л уусмал ногдоно.
- Нэмэлт бордоог бүрхэг өдөр буюу нарны илч буурсан оройн цагаар үүргэвчин шүршүүр хэрэглэж шүршинэ.
- Бордоог 3-6 цагийн турш устай хольж хутгаж сайтар уусгаад 4-5 давхар марли буюу шуудай зэрэг зүйлээр шүүж хэрэглэнэ.

Тарьцын өвчин ба түүнтэй тэмцэх

- Шинэсний цухуйц гарснаас хойш 3-12 хоногийн дотор налах өвчин илрэх бөгөөд энэ үед ургамал ба хөрсийг 0.5%-ийн манганы хүчлийн давсны уусмалаар 1м талбайд 5л ногдохоор шүршинэ.
- Дараа нь 30-40 мин болоод ургамал ба хөрсийг 1м талбайд 6- 8л ус ногдохоор шүршинэ.
- Шүршилтийг бүрхэг өдөр буюу 17 цагаас хойш гүйцэтгэнэ.
- Эгэл шютте өвчинтэй тэмцэхийн тулд 6 сарын 2-р хагасаас эхлээд цинеб /80%/, буюу коллоид хүхрийн шингэнээр 14 хоногийн зайтайгаар намрын хучилт хийх хүртэлх хугацаанд ургамлыг шүршинэ.
- Гадна рчнөөс өвчний халдвар оруулахгүйн тулд хүлэмжийн ханыг 0,5% маргенцийн уусмалаар шүршиж байна.

Тарьц ухаж авах ба шилжүүлж суулгах

- Намар шилжүүлж суулгах шинэсний тарьцыг 9 сарын эхээр ухаж авна.
- Хавар шилжүүлж суулгах шинэсний тарьцыг намар ухаж авч хадгалах
- Стандартад нийцэхгүй тарьцыг 2 дахь жилд нь үргэлжлүүлэн хүлэмжинд ургуулна.
 - Хоёр дахь жилд нь тарьцын шилмүүс үүсч эхэлснээс хойш 10 хоногийн дотор үйлчлэх бодисоор N50, P60, 6 сард P50, 8 сард P30 K20 кг.га аар тооцож нэмэгдэл бордоо өгнө.
 - Шинэсний тарьцыг 2 дахь жилд нь нийлэг хальсаар хучихгүйгээр, арчилгаа сайн хийвэл стандартын шаардлага бүрэн хангасан тарьц гарган авах боломжтой.